

БАТЛАВ: МВХ-ны ЕРӨНХИЙЛӨГЧ

Т.БАЯРХҮҮ

**МОНГОЛЫН ВОЛЕЙБОЛЫН ХОЛБООНЫ ЗАЛУУЧУУДЫН УЛСЫН АВАРГА
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР**

1. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ

Монголын Волейболын Холбоо

Хаяг: МҮОХ-ны байр, 402 тоот

Утас / Факс: 976 –11-344340; 99090301; 95731789

Цахим шуудангийн хаяг: info@mva.mn

2. ТЭМЦЭЭНИЙ ХУВААРЬ

Тэмцээний өдрүүд: 2020 оны 11-р сарын 02 - 08 -ны хооронд явагдана.

3. ЗОХИОН БАЙГУУЛАГЧ ХОТ & ТЭМЦЭЭН БОЛОХ ГАЗАР

Улаанбаатар хот, Спортын төв ордон

4. ОРОЛЦОГЧ БАГУУД

4.1 Клубууд, аж ахуйн нэгж, аймаг, дүүрэг, нутгийн зөвлөл, их дээд сургууль, сайн дурын хамтлаг зэргээр нээлттэй баг бүрдүүлэн оролцоно.

4.2 Зохион байгуулагчид нь иргэний үнэмлэх, гадаад паспорт болон холбогдох иргэний бичиг баримтыг шалгасны үндсэн дээр тэмцээнд оролцох мандатыг олгоно.

5. БАГИЙН МЭДҮҮЛЭГ БА МЭДЭЭЛЭЛ

5.1 Залуучуудын УАШТ-нд оролцох багууд нь 10-р сарын 25-ны дотор зохион байгуулах хороонд оролцох урьдчилсан мэдүүлэг /маягт MVA 0103001/ мэдүүлгийг zoldelger.h@gmail.com илгээнэ.

5.2 Техникийн зөвлөгөөн дээр эцсийн мэдүүлэг /маягт MVA 0103002/, эрүүл мэндийн хуудас /маягт MVA 0103004/, 1 хувь цээж зураг, иргэний үнэмлэх түүнтэй адилтгах хүчин төгөлдөр бичиг баримтыг авч ирсэн байна. Бичиг баримт, цээж зураг авчраагүй тохиолдолд сугалаанд оролцохгүй.

6. ТЭМЦЭЭНИЙ СИСТЕМ

6.1 Багуудыг хэсэгт хуваагдан тойргийн системээр тоглоно.

6.2 Хэсгээс шалгарсан багууд шигшээ тоглолтод олимпийн системээр тоглож дүнгээ гаргана.

6.3.1 Тоглолтын талбай дээр албан ёсны ажиллагаа эхлэхээс өмнө багууд бие халаалтыг хугацаа харгалзалгүйгээр хийж болно.

6.3.2 Албан ёсны бие халаалт 17 минут үргэлжилнэ.

6.3.3 Албан ёсны мэдүүлэгт ороогүй албаны хүмүүс бие халаалтын үед талбай дээр гарч болох бөгөөд тэмцээн эхэлснээс хойш 1-р шүүгчийн зааврыг дагана.

7. БЭЛТГЭЛ АЖЛЫГ ХЯНАХ, ТАЙЛАГНАХ БА СУГАЛАА

7.1 Зохион байгуулагчид нь Монголын Волейболын Холбооны тэмцээн зохион байгуулах журмыг чандлан мөрдөнө.

7.2 Албан ёсны сугалааг 2020 оны 10дугаар сарын 31-нд 14:00 цагаас МҮОХ-ны хурлын танхимд техникийн зөвлөгөөнийг зохион байгуулна.

8. ТОГЛОЛТЫН ДАРААЛАЛ, ЗОХИОН БАЙГУУЛАГЧИЙН ҮҮРЭГ

- 8.1 Сугалааны үр дүнг үндэслэн тоглолтын дарааллыг тогтооно.
 8.2 Зохион байгуулагч нь хэвлэл мэдээлэл, ТВ-ийн нэвтрүүлгийн улмаас тоглолтын хуваарийг өөрчлөх эрхтэй. Өөрчлөгдсөн хуваарийг тухайн багуудад 24 цагийн өмнө мэдээлэх шаардлагатай.

9. БАГУУДЫГ ДҮГНЭХ

- 9.1 Тойргийн тоглолтын дүн гаргахдаа хамгийн олон оноо авсан баг нь тэргүүлэх эрэмбийг баримтална.
 9.2 Тойрогт байгаа багуудыг байр эзлүүлэхдээ эхлээд хожлын онооны нийлбэр, хожсон болон хожигдсон ээлжийн нийлбэр, ээлж болгонд хожсон болон хожигдсон ээлжийн онооны нийлбэр гэсэн дараалал баримтална.

| | |
|---|--------------------|
| Тоглолтод баг 3:0 харьцаагаар хожсон бол | 3 оноо |
| Тоглолтод баг 3:2 гэсэн харьцаагаар хожсон бол | 2 оноо |
| Тоглолтод баг 2:3 гэсэн харьцаагаар хожигдсон бол | 1 оноо |
| Тоглолтод баг 0:3 харьцаагаар хожигдсон бол | 0 оноо |
| Тоглолтод оролцоогүй бол | 0 оноо (25-0;25-0) |

- 9.2.2 Багуудын харьцааг гаргахдаа хожлын нийлбэрийг хожигдолын нийлбэрт хуваасан үлдэгдэлийн харьцаагаар эрэмбэлнэ.
 9.2.3 Хэрвээ хоёр ба түүнээс олон баг ижил оноо авсан бол эрэмбэлэхдээ ээлжийн тоглолтын хожсон болон хожигдсон онооны харьцаагаар шийднэ.
 9.2.4 Хэрвээ багуудын оноо тэнцүү хэвээр байвал эрэмбэлэхдээ нийт ээлжийн /sets/ онооны хожил ба хожигдсон тооны харьцаагаар шийднэ.
 9.2.5 Хэрвээ хоёр багийн оноо дахин тэнцүү хэвээр байвал тухайн хоёр багийн тоглосон тоглолтуудын үр дүнгийн дагуу эрэмбэлнэ.
 9.2.6 Хэрвээ баг тоглолтын явцад эрхээ хасуулбал тэмцээнээс хасагдах бөгөөд өмнөх тоглолтын бүх үр дүнгүүдийг тэглэнэ. Эсрэг тоглосон багуудыг тухайн тоглолтын ялагч гэж үзнэ. Тойргийн тоглолтын оноолтод байгаа ч тоглоогүй 0 оноо авсан багийн эсрэг багт хожлын оноо 2 гэж өгөөд ээлжийн оноог 50 /2 ээлж бол/ гэж тэмдэглэн дүнг гаргана.
 9.2.7 Оноо авсан багуудыг амжилтаар нь эрэмбэлнэ.

10. ТЭМЦЭЭНИЙГ ШҮҮХ

- 10.1 Залуучуудын улсын аварга шалгаруулах тэмцээнийг Монголын волейболын холбооны тэмцээн зохион байгуулах журам, Олон улсын волейболын холбооны тоглолтын дүрмийн дагуу явуулна.
 10.2 Монголын волейболын холбооны Шүүгчдийн зөвлөлөөс томилогдсон шүүгчид тэмцээнийг шүүнэ.

11. ЭМНЭЛГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ БА ХЯНАЛТ

- 11.1 Багийн бүх гишүүд нь сүүлийн 2 сарын хугацаанд баталгаажуулсан эрүүл мэндийн хуудас /маягт MVA 0103004/-ыг бөглөн ирүүлнэ.
 11.2 Тэмцээний туршид ажиллах эмчийг Зохион байгуулах хороо томилно.
 11.3 Анхны яаралтай тусламжийг Зохион байгуулах хороо үзүүлнэ.
 11.4 Эмнэлгийн үзлэг, уулзалтын өрөөг Зохион байгуулах хороо бэлдсэн байна.
 11.5 Баг нь бүх гишүүдийнхээ эрүүл мэндийг даатгалыг хариуцна.

12. УРЬДЧИЛСАН ШАЛГАЛТ

- 12.1 Урьдчилсан шалгалтыг техникийн зөвлөгөөний үеэр зохион байгуулна.
 12.2 Урьдчилсан шалгалтыг Олон улсын волейболын холбооны дүрмийн дагуу гүйцэтгэнэ.

- 12.3 Багийн менежер, дасгалжуулагч, эмч нар энэ шалгалтын үеэр байлцах шаардлагатай:

Шалгалтад дараах бичиг баримтыг бүрдүүлнэ:

- Эцсийн мэдүүлэг /MVA 0103002 / маягт, тамга, тэмдэг, алдаа засваргүй байх
- Бүх тоглогчдын иргэний үнэмлэх ба түүнтэй адилтгах хүчин төгөлдөр бичиг баримт
- Эрүүл мэндийн хуудас /MVA 0103004/ маягт, тамга, тэмдэг, алдаа засваргүй байх
- Багийн тоглолтын хувцас (2 өнгө)

13. ТЕХНИКИЙН ЗӨВЛӨГӨӨН

- 13.1 Техникийн зөвлөгөөнд багийн менежер, дасгалжуулагч, эмч, ахлагч нар оролцоно.
- 13.2 Техникийн зөвлөгөөнийг Олон улсын волейболын холбооны дүрмийн дагуу удирдан явуулна.
- 13.3 2020 оны 10 дугаар сарын 31-нд 14:00 цагаас МҮОХ-ны 407 тоотод техникийн зөвлөгөөнийг зохион байгуулна.

14. ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ НАС

- а) Тэмцээнд МВХ-ны тэмцээн зохион байгуулах журмыг үндэслэн 1999.01.01 –нээс хойш төрсөн 21 наснаас доош насны тамирчид оролцоно.
- б) Зааварт заасан ангилалын бус тамирчин оролцсон тохиолдолд эцсийн мэдүүлэгт ороогүй тамирчин тоглосон тохиолдолд багийг тэмцээнээс хасна. Мөн зааварт заасан ангилалын бус тамирчин оролцсон тохиолдолд тухайн багийн дасгалжуулагч болон тамирчны эрхийг хасна.

15. ХЭВЛЭЛ, МЭДЭЭЛЭЛ

- 15.1 Багуудын танилцуулга, тэмцээнд оролцож буй амжилтын талаар тухайн багууд хэвлэлийн бага хурал хийлгэх болон тэмцээнийг сурталчлах ажлыг зохион байгуулагчид хариуцна.
- 15.2 Тэмцээний өдөр тутмын дүнг багуудад мэдээлнэ.

16. АЛБАН ЁСНЫ ДҮРЭМ, БӨМБӨГ

- 16.1 Олон улсын волейболын холбооны тоглолтын дүрмийн дагуу явуулна. Шүүгчдийн шалгалтын дүнгээр ямар нэгэн өөрчлөлт гарч болох ба техникийн зөвлөгөөн дээр танилцуулна.
- 16.2 Тэмцээнийг MIKASA Volleyball V200 W маркийн бөмбөгөөр явуулна.

17. ХУВЦАС

- 17.1 Тоглолтын хувцас Монгол улсын стандартад нийцсэн байна. Баг тус бүр 2 өнгийн хувцастай байх ба зөвхөн нэрийн мэдүүлэгт баталгаажуулсан хувцсыг өмсөнө.
- 17.2 Хувцасыг буруу өмсөх, стандартыг дагаж мөрдөөгүй тохиолдолд дүрмийн дагуу торгууль хүлээнэ. (МВХ-ны Тэмцээн зохион байгуулах дүрмийн дагуу) МВХ-ноос зохион байгуулагдаж буй тэмцээнд оролцож байгаа багууд тоглолтын болон бэлтгэлийн хувцсан /өмсгөл/дээр төрийн далбааг ашиглахыг хориглох бөгөөд төрийн далбаатай өмсгөл хувцастай тоглолтонд оролцуулахгүй./Төрийн далбааг зөвхөн шигшээ багийн тамирчдын өмсгөл хувцсан дээр ашиглана/
- 17.3 Тоглолтын хувцасыг урьдчилсан шалгалтын үеэр шалгуулж баталгаажуулна.

17.4 Багийн сандал дээр суух албаны хүмүүс дараах шаардлагуудын аль нэгийг хангана:

- I. Багийн бүх гишүүдийн адил ижил өнгийн хувцас өмсөх
- II. Албан ёсны костюм өмсөж, зангиа зүүх
- III. Бэлтгэл хангагчаас бусад нь албан ёсны хувцас өмсөх.
- IV. Албан ёсны хувцас өмсөөгүй бол багийн гишүүдтэй ойртохыг хориглох ба багийн гишүүдтэй ижил хувцас өмссөн тохиолдолд харилцаа үүсгэнэ.

18. МАРГААН

- 18.1 Тухайн тоглолт дууссанаас 30 минутын дотор багийн менежер эсвэл ахлах дасгалжуулагч 300 000 төгрөгний барьцаатай гомдол гаргах эрхтэй.
- 18.2 Нас хэтэрсэн тамирчин тоглосон багийг тэмцээнээс хасаж тоглолтын үр дүнг тэглэнэ.

19. БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

- 19.1 Баг тус бүр 16 гишүүдээс бүрдэнэ: 12 тоглогч, багийн менежер-1, ахлах дасгалжуулагч-1, туслах дасгалжуулагч-1, эмч-1 байна.
- 19.2 Багууд дагалдах шүүгчтэй байж болно.
- 19.3 Тэмцээн эхлэхээс өмнө багийн илүү албаны төлөөлөгчдийн зардлыг шийдвэрлэсэн бол 2 хүртэлх хүний мандатыг олгож болно.
- 19.4 Багийн албаны хүмүүс багийн сандал дээр суух ба онцгой тохиолдлоос бусад үед өөрчлөлт хийхийг хориглоно.
- 19.5 Багийн тоглогчын тоо хамгийн багадаа 9 байж болно.

20. САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ

- 20.1 Баг тус бүр дараах зардлыг хариуцана:
 - a) Байр хоолны зардал
 - b) Эрхийн төлбөр 800,000 (баг тус бүр)
 - c) Мандат 5000 төг
 - d) Гишүүнчлэлийн хураамж 20000 төг/тамирчин тус бүр/
- 20.2 Зохион байгуулах хороо нь:
 - a) Эмнэлгийн анхны тусламж
 - b) Тэмцээнтэй холбоотой болон зохион байгуулалтын бүх зардал

21. ШАГНАЛ

- 21.1 Медалийг 12 тамирчин 2 дасгалжуулагч 1 багийн эзэнд олгоно.
Тэмцээнд амжилттай оролцож эхний 3-н байр эзэлсэн тамирчдад медаль, диплом, мөнгөн шагнал олгоно.
- 21.2 Тамирчны үр чадварыг харгалзан эрэгтэй, эмэгтэй тус бүрт шилдэг тэгш тоглогч, шилдэг холбогч, шилдэг довтлогч, шилдэг хамгаалагч, шилдэг хаагч нийт арван тамирчин, хоёр дасгалжуулагч, нэг шилдэг шүүгчийг шалгаруулан тусгай шагналаар шагнаж урамшуулна.

22. БОЛЗОШГҮЙ ЗҮЙЛ

Зааварт тусгагдаагүй гарч ирсэн асуудлыг Зохион байгуулах хороо өөрийн эрх мэдлийн хүрээнд шийдвэрлэнэ.

МОНГОЛЫН ВОЛЕЙБОЛЫН ХОЛБОО

ЗОХИОН БАЙГУУЛАХ ХОРОО